

БАТЛАВ.
“ДЦС-4” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
...../...../ ОМӨРХУЯГ/

БАТЛАВ.
ХОСХИЙМОРЬ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
...../...../ Б.НАСАНЖАРГАЛ/

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ /УУР/ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№.../2020-52

2020 оны 01-р сарын 31-ны өдөр

Нэг талаас “ДЦС-4” ТӨХК-ийг төлөөлж Бизнес үйлчилгээ эрхэлсэн дэд захирал Б.Сандуйжав /цаашид худалдагч гэх/, нөгөө талаас Хосхийморь ХХК-ийн нягтлан бодогч Л.Ганхуяг /цаашид худалдан авагч гэх/ нар Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Хэмжил зүйн нэгдмэл байдлын тухай хуулийн заалтуудыг үндэслэн 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаатай дор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав. Гэрээг үргэлжлүүлэн сунгах эсвэл шинээр байгуулах тухай хэлцэл явагдаж байх хугацаанд энэхүү гэрээг мөрдөнө.

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Худалдагч тал худалдан авагчийн захиалсан дулааны эрчим хүч $P=8\text{ата} \pm 5\%$ даралттай $t=170^{\circ}\text{C} \pm 5^{\circ}\text{C}$ халуун уураар энэхүү гэрээнд заасан тоо хэмжээний дагуу худалдах, худалдан авч хэрэглэсний төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн хийх, гэрээ байгуулагч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, шаардлагатай бусад нөхцлүүдийг харилцан тохиролцов.
- 1.2 Энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдон гарах, гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны журам, Дулаанаар зохицуулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгчийн хоорондын аж ахуйн харилцааны дүрэмийн заалтуудыг үндэслэн зохицуулна.
- 1.3 Гэрээг хавсралтуудын хамт 3 хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр нь хуулийн хүчин төгөлдөр байна.

Хоёр. ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Худалдан авагч нь “Эрчим хүчний тухай” хуульд зааснаас гадна дараах эрхтэй.
 - 2.1.1 Захиалгын хуудсанд заасан стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангагдах
 - 2.1.2 Дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагааны талаар худалдагч талын холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгөх, санал хүсэлт, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх
 - 2.1.3 Стандартын шаардлага хангаагүй дулааны эрчим хүч нийлүүлсэн тохиолдолд төлбөрийн акт баримтыг үндэслэн учирсан хохирлоо нэхэмжлэх
 - 2.1.4 Гэрээнд өөрчлөлт оруулах бол энэ тухай хүсэлтийг худалдагч талд бичгээр гаргаж шийдвэрлүүлэх
- 2.2 Худалдан авагч тал энэхүү гэрээгээр дараах үүргийг хүлээнэ.
 - 2.2.1 Худалдан авагч тал захиалсан дулааны эрчим хүчийг худалдан авч Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос баталсан тарифын дагуу төлбөрийг төлөх үндсэн үүрэг хүлээнэ.
 - 2.2.2 Дулааны эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах
 - 2.2.3 Өөрийн эзэмшлийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах, ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, тоног төхөөрөмжийн тохируулга, тооцоолол, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах

- 2.2.4 Худалдан авагч тал дулааны тоолуурын ажиллагаа алдагдсан, түүнд гэмтэл гарсан болон гарч болзошгүй нөхцөл байдал үүссэн үед худалдагч талд яаралтай мэдэгдэх ба өөрийн буруугаас тоолуур, тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл гэмтэл учруулсан нөхцөлд учирсан хохирлыг худалдан авагч барагдуулах үүрэгтэй
- 2.2.5 Дулааны шугам, тоног төхөөрөмжид гэмтэл саатал гарвал худалдагч талд нэн даруй мэдэгдэж үндсэн сүлжээнээс тусгаарлах арга хэмжээ авах үүрэгтэй
- 2.2.6 Худалдагч талаас олгогдсон техникийн нөхцөлийн дагуу бусад хэрэглэгчийг өөрийн өмчлөл, эзэмшлийн дулааны шугамаас саадгүй холбуулах, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоолуурын мэдээллийг үнэн зөв мэдүүлж, гэрээнд тусгуулах
- 2.2.7 Худалдан авагч талын хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг, үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч өөрчлөгдсөн бол ажлын 5 хоногийн дотор худалдагч талд албан ёсоор мэдэгдэж, өөрчлөлтийг гэрээнд тусгуулах
- 2.2.8 Үл хөдлөх хөрөнгө эзэмшигч нь өөрийн эзэмшлийн газар, байшин барилгаа бусдад түрээслүүлэх, эзэмшүүлэх, худалдахдаа хэрэглэсэн эрчим хүчний тооцоогоо хийж, гэрээг дуусгавар болгосон байна. Хэрвээ гэрээ дуусгавар болгоогүй нөхцөлд үүссэн төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдлийг гэрээ хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцан барагдуулах үүрэгтэй.
- 2.2.9 Шинээр баригдах, өргөтгөл шинэчлэл хийх барилга байгууламжинд дулааны эрчим хүч авах, ачааллыг өөрчлөх техникийн шийдлийг өөрчлөх, шинэчлэл хийх тохиолдол бүрт худалдагчаас техникийн нөхцөл шинээр авна.
- 2.2.10 Худалдан авагч тал дулааны эрчим хүчээр хангагдах хүсэлтээ худалдагч талд 3-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэж, худалдагч талын төлөөлөгчийг байлцуулан хаах, нээх үйлдлийг гүйцэтгэнэ.
- 2.2.11 Худалдан авагчийн эрх бүхий ажилтныг орон байрандаа саадгүй нэвтрүүлэх үүрэгтэй
- 2.2.12 Нөхөн тооцооны төлбөр, алданги, дулааны хэрэглээг түдгэлзүүлсэн, дулаан хангамжийг сэргээх, бусад үйлчилгээний төлбөр хураамжуудыг зохих журмын дагуу төлөх үүрэгтэй
- 2.2.13 Худалдан авагч гэрээ шинээр байгуулах болон дулааны эрчим хүчний хэрэглээний тоо хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүр дулааны эрчим хүчний захиалгыг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.
- 2.2.14 Худалдан авагч нь захиалсан уурыг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан авч чадаагүй бол шугамыг халуун бэлтгэлд байлгаж болох бөгөөд тоолуурын заалтаар төлбөрөө тооцож төлнө.

ГУРАВ. ХУДАЛДАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Худалдагч тал дараах эрхийг эдэлнэ.
 - 3.1.1 Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасны дагуу худалдан авагчийг дулааны эрчим хүч/уур/-ээр хангана.
 - 3.1.2 Худалдан авагчийн шугам хоолой, худаг, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, хяналт тавих зохилгоор барилга байгууламжинд нэвтрэх, гэрээний үүргийн биелэлтийг шалгаж дүгнэх үед зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгуулах мэдэгдэл өгөх, нөхөн төлбөр тавих, алданги тооцох зэрэг хариуцлага тооцож, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд дулааны эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлэх эрхтэй.
 - 3.1.3 Худалдан авагч тал гэрээнд болон актанд заасан хугацаанд дулааны төлбөрөө төлөөгүй бол гэрээг дангаараа цуцлах, гадна агаарын температураас үл хамааран эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлж, үүнээс үүдэн гарах хохирлыг худалдагч тал хариуцахгүй.
 - 3.1.4 Худалдан авагчийн уурын шугамын тоноглолын угсралт, засвар, угаалга шахалт шалгалтын чанар үйлчилгээнд “Даралт сав шугам хоолойн ашиглалт угсралтын дүрэм”-ийн дагуу шаардлага тавих эрхтэй бөгөөд зөрчилтэй гэж үзвэл Улсын мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулах эрхтэй.

- 3.2 Худалдагч тал дараах үүргийг хүлээнэ.
- 3.2.1 Худалдагч гэрээнд заасан хугацаанд худалдан авагч талыг дулааны эрчим хүчээр тасралтгүй хангана.
- 3.2.2 Худалдагч тал дулаан дамжуулах шугамын засвар үйлчилгээ, тохируулга хийх бол 72 цагийн өмнө, аваарийн нөхцөл байдал үүссэн үед худалдан авагчдад 4-өөс доошгүй цагийн өмнө зогсолтын тухай мэдэгдэл өгч байна. Дулаан дамжуулах үндсэн тоноглол, шугаманд гарсан эвдрэл, гэмтлийн улмаас дулаан нийлүүлэх боломжгүй нөхцөл үүссэн үед худалдан авагч талд үүссэн нөхцөл байдал, түүний үргэлжлэх хугацааны тухай нэн даруй мэдэгдэнэ.
- 3.2.3 Худалдагч нь уурын параметрийн доголдол, хэлбэлзлийн талаар гэрээнд заасан нөхцлийг зөрчсөнөөс гарсан гомдлын дагуу шуурхай арга хэмжээ авах бөгөөд гарсан хохирлыг газар дээр нь акт тогтооход бие төлөөлөгчөө оролцуулах үүрэгтэй.
- 3.2.4 Худалдагч тал дулаан хангамжийн талаарх худалдан авагч талын гаргасан санал гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор багтаан шийдвэрлэж, хариуг өгөх бөгөөд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахад холбогдох баримт, горимын тооцоог үндэслэн шийдвэрлэнэ.
- 3.2.5 Худалдагч тал ЭХЗХ-ны баталсан тогтоол, шийдвэрээр худалдан авагч талаас дулааны эрчим хүчний үнэ тариф болон үйлчилгээний төлбөр хураамжийг авч хэрэв уг тогтоолд өөрчлөлт орсон тохиолдолд заасан хугацаанаас эхлэн дагаж мөрдөх үүрэгтэй.

ДӨРӨВ. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦОХ НӨХЦӨЛ

- 4.1 Талууд дулааны эрчим хүчний тооцоонд Эрчим Хүчний Зохицуулах хорооны баталсан үнэ тарифыг мөрдөх бөгөөд үнэ тарифыг өөрчилсөн тохиолдолд заасан хугацаанаас эхлэн төлбөр тооцоондоо мөрдөнө. ЭХЗХ-ны 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 122 тоот тогтоолоор баталсан 1 ГДж уурын тарифт үнийг 5397 төгрөг/НӨАТ ороогүй/-өөр тооцож байгаа бөгөөд 1 тн хувирсан ус/конденсат/-ны үнийг 2260 төгрөгөөр /НӨАТ ороогүй/ тооцно.
- 4.2 Уураар түгээсэн дулааны төлбөр тооцоог худалдагч болон худалдан авагчийн шугамын зааг дээрээс эхлэн тооцно. Төлбөр тооцооны тоолуурыг шугамын заагаас зайтай байрлуулсан бол дулааны эрчим хүчний тооцоонд шугамын заагаас тоолуур хүртэлх шугамын алдагдлыг тооцож оруулна.
- 4.3 Худалдан авагчийн тоолуурын заалтыг үндэслэн дулааны эрчим хүчний төлбөрийг сар бүрийн 28-ны дотор sales@tpp4.mn и-мэйл хаягаас худалдан авагчийн гэрээнд заасан албан ёсны и-мэйл хаягт илгээнэ. Цахим шуудангаар илгээсэн өдрөөр төлбөрийг нэхэмжилсэнд тооцно. Хэрэглэгч нэхэмжлэх илгээснээс хойш 10 хоногийн дотор төлбөрийг бүрэн төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй буюу дутуу төлсөн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,5 хувийн алданги төлнө. Энэ нь төлөөгүй үнийн дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна. /Гуравдагч этгээдээр дамжуулан тушаасан мөнгөтэй холбогдон гарах маргааныг худалдагч тал хариуцахгүй./
- 4.4 Худалдан авагчийн шугамын алдагдлыг тухайн сарын түгээсэн дулааны эрчим хүч-уурын дулааны 10%, уурын чийглэгийн алдагдлын коэффициентийг ЭХЗХ-ны шийдвэрийн дагуу өвлийн улиралд 5%, зуны улиралд 10% -иар тооцож тооцоонд нэмж тооцно.
- 4.5 Худалдагч талын эрх бүхий ажилтан худалдан авагчийн тоолуурын лац, ломбоны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянаж, сарын тоолуурын бичилт, тооцооны хуудас дээр параметрийг тэмдэглэж, худалдан авагч талын эрх бүхий төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулсан хуудсыг үндэслэн сарын төлбөрийг тооцно.

- 4.6 Тоолуургүй хэрэглэгчийн тооцоог гэрээнд заасны дагуу төлбөрийг тооцно. Тоолуур ажиллаагүй нөхцөлд тооцоо хийх аргачлалыг худалдагч, худалдан авагч харилцан тохиролцож хийнэ. Худалдан авагчаас үл хамааран тоолуур ажиллаагүй бол сарын дунджаар бодож худалдан авагчтэй тохиролцож тооцоо хийж байна
- 4.7 Худалдан авагч нь хэмжих хэрэгслийг гэмтээсэн, гэмтлийн талаар тодорхой мэдээлэл өгөөгүй төөрөгдүүлж будлиантуулсан тохиолдолд уг хугацааны төлбөрийг тоолуургүй үеийн зураг төсөлд заасан дулааны ачааллыг үндэслэн суурилагдсан хүчин чадлыг хуанлийн цагаар бодож тооцно.
- 4.8 Худалдан авагчийн хэмжүүрийн заалт НС 8 цагаас дээш гарсан тохиолдолд уурын хэмжүүрийн заалт дээд хязгаараас хэтэрсэн цагийн төлбөрийг хэмжүүрийн заалтын дээд хязгаарыг 20%-иар нэмэгдүүлснээр тооцож төлбөрийг авна. Шайбтай хэмжүүртэй тохиолдолд сард 48 цагаас илүү гарсан, мөн давтагдан гарвал хэмжүүрийн шайбыг өөрчлөх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.9 Худалдан авагч эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн, тоолуурын архивын хугацааг засварласан, тоолуурын хугацаат санамжийн тоолол тасалдуулсан, тэжээлийг тасалсан зэрэг зөрчлийг үйлдсэн болохыг худалдагчийн эрх бүхий ажилтан илрүүлсэн бол уурын тооцоог суурилагдсан хүчин чадлаар тооцож төлбөрийн хэмжээг тодорхойлно.
- 4.10 Худалдан авагчийн хэмжүүр нь мэдрэхгүй зоноор ажиллаж уурын температур унаагүй тохиолдолд тоолуурын НС-ийн доод горимд тоолсон цагийг харгалзах зарцуулалтын утгаар тооцож төлбөр тооцоонд авна.
- 4.11 Талуудын хооронд хэмжих хэрэгсэл , хэмжүүрийн талаар харилцан хүлээх үүрэг хариуцлагыг уурын тооцооны хэмжих хэрэгсэл ашиглах журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 4.12 Худалдагч төлбөрийн нэхэмжлэл, цахим мессэж, мэдэгдэл хүргүүлснээс хойш мэдэгдэлд заасан хугацаанд худалдан авагч төлбөрөө төлөөгүй бол дулааны эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлэх тухайгаа 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ. Мэдэгдэлд түдгэлзүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж, тоног төхөөрөмж, тоолуур, хэмжүүр зэрэг шаардлагатай бусад хэрэгслийг битүүмжилнэ.
- 4.13 Худалдан авагч тал эзэмшлийн заагаар өөрийн хэсэгт тавигдсан дулааны тоолуур, хэмжих хэрэгслийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дурмэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан болон, тоолуур гэмтэлтэй байгаа нь тогтоогдвол төлбөр тооцоог худалдагч тал уг барилга объектын зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн тооцоот ачааллаар тооцон төлүүлнэ.
- 4.14 Талууд гэрээний хугацаа дуусахад санхүүгийн тооцоог нийлж, хамтарсан актаар баталгаажуулж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.

ТАВ. ТАЛУУД ХООРОНДЫН БУСАД ХАРИЛЦАА

- 5.1 Стандартын шаардлага хангаагүй дулааны эрчим хүч нийлүүлж, хохирол гарсан тохиолдолд хоёр талын төлөөлөгч байлцан шалтгааныг тодруулан хамтарсан акт протокол үйлдэж баталгаажуулна.
- 5.1 Энэхүү гэрээ болон түүний хавсралт хэсэгт өөрчлөлт орох бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа талууд албан бичгээр ирүүлэх бөгөөд асуудлыг хоёр тал хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Гэрээний нэмэлт өөрчлөлт дээр талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр болно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Худалдагч талаас гэрээний үүргийн биелэлттэй холбоотой өгсөн албан шаардлагын хугацаанд зөрчлөө арилгаагүй бол гэрээ түдгэлзүүлэх тухай мэдэгдэл өгөх ба 3 хоногийн дараа дулааны шугамын таслалтыг гүйцэтгэнэ. Цаашид

зөрчилөө арилгахгүй , давтан гаргасан тохиолдолд нэг талын санаачлагаар гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

6.2 Гэрээний талаар маргаан гарвал талууд маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй бол Эрчим хүчний зохицуулах газарт болон Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдагч талыг төлөөлж:
Бизнес үйлчилгээ эрхэлсэн
Дэд захирал Б.Сандуйжав
БМА-ны дарга
..... С.Алтанхуяг
СБХ-ийн дарга бөгөөд Ерөнхий ня-бо
..... Д.Төмөртоого
Хуулийн зөвлөх..... Ч.Бямбасүрэн
Гэрээний мэргэжилтэн
..... С.Донид

РД:2688352

Харилцах банк:ХХБ 806-р салбар
Дансны дугаар: 406001049
Харилцах банк: Төрийн банк
Дансны дугаар:102100001107
Харилцах банк:ХААН банк
Дансны дугаар:5038008126
Харилцах банк:Голомт банк
Дансны дугаар:1102038052
Харилцах утас:7000-2245
7017-0783

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо
Эрчим хүчний гудамж

Худалдан авагч талыг төлөөлж:

Нягтлан бодогч

.....
..... Л.Ганхуяг

РД:5434017

Харилцах банк:Хаан
Дансны дугаар:
Харилцах банк:
Дансны дугаар:

Нэхэмжлэх хүлээн авах
албан ёсны и-мэйл хаяг:
ganhuyag.lonjid@yahoo.com
Харилцах утас: 9906-8109
9914-8109

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо
Үйлдвэрлэлийн бүс

4/2020-52
 тоот гэрээний хавсралт №1

Дулааны эрчим хүчний 2020 оны хэрэглээний захиалга

Хугацаа	Захиалга Гдж	Хугацаа	Захиалга Гдж
1 сар	1200.	7 сар	1000.
2 сар	500.	8 сар	1200.
3 сар	1300.	9 сар	1000.
4 сар	1000.	10 сар	1500.
5 сар	200.	11 сар	2500.
6 сар	500.	12 сар	800.
Жилийн дүн			14900.

Худалдагчийг төлөөлж:
 ДЦС-4 ТӨХК-ийн
 БМА-ны борлуулалтын менежер
/Д.Гантөмөр/

Худалдан авагчийг төлөөлж:
 ХХК-ийн
 Нягтлан бодогч
 Л.Ганхуяг

